



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/320

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Төв Петровис шатахуун түгээх станцаас Ховд их сургуулийн уулзвар хүртэлх авто зам дагуух талбайн тохижилтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ганзориг - Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын Улсын байцаагч

Гишүүд:

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Д.Цогтхүү - Стандарт хэмжилзүйн хэлтсийн байцаагч

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга

Ш.Дамдинсүрэн - “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН